БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

## ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН

**Орон нутагт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал хуваариладаггүйгээс хүнсний аюулгүй байдлыг сайжруулах цогц хөтөлбөрийн зорилт хангалттай хэрэгжээгүй, бодит үр дүн гаргаагүй байна.**

**АУДИТЫН КОД: БУА-2021/14-5/ШТА-ГА**


Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2716 Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn
Аудитор: Э.Одбаясах
Утас: 7034-2495 Цахим хаяг: Odbaysakhe@audit.gov.mn


БУЛГАН АЙМАГ
2021 ОН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/21 Булган

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлага, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын гуравдугаар газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ болон холбогдох газрын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-т даалгасугай.

5.Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг аудитор /Г.Цэрэнлхам/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D: /bnchig hereg/2021/tushaal/TAtushaal.doc

006010071

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУБ | Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АЗДТГ | Аймгийн Засаг Даргын тамгын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗГҮАХ | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| МАА | Мал аж ахуй |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| МУЗГ | Монгол улсын Засгийн газар |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| МЭГ | Мал эмнэлгийн газар |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| СХЗХ | Стандарт хэмжил зүйн хэлтэс |
| УИХ | Улсын их хурал |
| ХАБҮЛЛ | Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори |
| ХХААГ | Хүнс хөдөө аж ахуйн газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## Хүснэгтийн товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| *Хүснэгт 1* | *Үйл ажиллагааны үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ* | *7* |
| *Хүснэгт 2* | *Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүдийн 2016-2020 оны хэрэгжилтийн тайлан* | *9* |
| *Хүснэгт 3* | *Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын тоон мэдээлэл* | *11* |
| *Хүснэгт 4* | *Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн 2016-2020 оны хүнсний бүтээгдэхүүний дээжийн дундаж үзүүлэлтийг итгэмжлэлийн үзүүлэлтийн харьцуулалт* | *14* |
| *Хүснэгт 5* | *Мал эмнэлгийн лабораторийн 2019-2020 оны итгэмжлэлийн үзүүлэлтийн харьцуулалт* | *15* |
| *Хүснэгт 6* | *Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2017-2018 онд хөтөлбөрүүдэд хуваарилсан зардал* | *21* |


## Хавсралтын товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| *Хавсралт 1* | *Мал эмнэлгийн лабораторид 2019 онд шинжилгээнд хамрагдсан дээж* | 25 |
| *Хавсралт 2* | *Мал эмнэлгийн газрын лабораторийн 2020 оны дээж* | 25 |
| *Хавсралт 3* | *Мэргэжлийн хяналтын газрын 2016-2020 онд шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний дээж* | *26* |
| *Хавсралт 4* | *Аймгийн 2018-2020 оны гол нэрийн хүнсний хангамж* | *27* |
| *Хавсралт 5* | *Мэргэжлийн хяналтын газрын 2016-2020 оны төлөвлөгөөт шалгалт* | *28* |
| *Хавсралт 6* | *Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2018-2020 оны баталгаажуулалт* | *28* |
| *Хавсралт 7* | *"Хүнсний аюулгүй байдал"-ын талаарх хийсэн сургалтын судалгаа* | *29* |
| *Хавсралт 8* | *Талбарт ажилласан ажлын зургаас* | *30-32* |

| | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл |
|---|---|
| **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх** | Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ. |
| **Аудитын зорилго** | Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.<br><br>Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>➢ Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх,<br>➢ Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх. |
| **Аудитын хамарсан хүрээ** | Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй төрийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, төр, хувийн хэвшлийн лаборториуд, хүнсний сүлжээний бүх шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулллаа. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн Аудитын Стандарт MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын гүйцэтгэлийн аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглалаа.<br><br>Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа. |

| | |
|---|---|
| **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа** | Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор Г.Намчинсүрэн нар чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Цэрэнлхам, А.Сувдаа, Э.Одбаясах нар гүйцэтгэлээ.<br><br>Аудитын төлөвлөгөөний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс аудитыг нээж эхлүүлэн, 2021 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ. |
| **Хүндрэл бэрхшээл:** | Аудитын төлөвлөгөөний дагуу аудитад шаардлагатай баримт материалыг удаа дараа шаардсан боловч аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ болон хэлтсийн холбогдох мэргэжилтэн баримт материал ирүүлдэггүй, баримт материал гаргаж өгөхгүй, аудит хийхэд саад учруулж байна. |
| **Ерөнхий мэдээлэл:** | Булган аймаг нь Монгол орны төвийн хойд хэсэгт 48.8 мянган ам км буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 3.1 хувийг эзэлж, хойд хэсгийн Хангайн бүсийн уулархаг хэсэгт оршдог бөгөөд хойд талаараа ОХУ-тай хиллэдэг. Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Төв, Архангай, Өвөрхангай аймгуудтай хөрш нутагтай.<br>Нийт талбайн 70 хувь нь ХАА-н эдэлбэр газар үүнээс 2.4 хувь тариалангийн газар, 2.3 хувь нь хадлангийн 58.5 хувь бэлчээрийн 28.7 хувь ой, 0.5 хувь усан талбай, 2 хувь нь тусгай хэрэгцээний болон нөөцийн газар болно.<br>16 сум, 1 тосгон, 75 багтай, 2019 оны жилийн эцсийн байдлаар 62214 хүн ам тоологдож, 0-35 насны 60.6 хувь, дундаж наслалт 72.8, хүн амын тоогоор 21 аймгаас 18-д, газар нутгийн хэмжээгээр 17-д, нягтшилаар 13-д ордог байна.<br>2019 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт 3.6 сая толгой мал тоологдсоноос үхэр-293602, хонь-1861270, адуу-274269, ямаа-1055160, тэмээ-1305 толгой байна. Малын тоогоор улсад 6-р байр эзэлдэг байна. |

| БҮЛЭГ 1 | ***Төрөөс батлан хэрэгжүүлсэн хөтөлбөр хоорондын уялдаа хангалтгүй, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах цогц зорилт хөтөлбөр хангалттай хэрэгжээгүй, бодит үр дүн гаргаагүй байна.*** |
|---|---|

***А.1 Төрөөс батлан хэрэгжүүлсэн хөтөлбөр хоорондын уялдаа хангалтгүй, зорилт бүрэн хэрэгжээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, үр дүнд хүрээгүй байна.***

1.1 УИХ, Засгийн газраас баталсан урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараах зорилт, арга хэмжээг тусгасан байна. Тухайлбал:

- *УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт 10 зорилтын 52 үйл ажиллагаа,*
- *УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1-т “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийн зорилтыг хангахаар “Хөдөө аж ахуйн салбар”-ын I үе шат (2016-2020)-нд 3 зорилт,*
- *УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэн, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдсэн, дунд хугацааны бодлого болох “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатанд /2016-2020 он/ 6 зорилтын хүрээнд нийт 176 арга хэмжээ,*
- *УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хүрээнд 30 зорилт хэрэгжүүлэхээр тус тус тусгасан байна.*

1.2 Аймгийн хэмжээнд Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын II хуралдааны 2016 оны 02/05 дугаар тогтоолоор 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэл, 02/06 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан байна.

1.3 Дээрх төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нийт 9 арга хэмжээг тусгажээ.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ*

*Хүснэгт №1*

| № | 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэл | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөр |
|---|---|---|
| 1 | МАА-г хөгжүүлэх бодлогыг шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлэх | Малын үржлийн ажил, үйлчилгээ, малын чанарыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлтийг хангана. |
| 2 | Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр /Мах, сүү, чацарганын үйлдвэрлэл г.м /санал санаачилгыг дэмжих бодлого баримтлан ажиллах/ | Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ. |
| 3 | | Хөдөөгийн иргэдийн хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. |
| 4 | | Мал эмнэлгийн үйлчилгээний олон улсын жишиг, стандартын шаардлагад нийцсэн, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог бүх шатанд бүрдүүлэх, мал эмнэлгийн нэгжүүдийг чадавхжуулж, мал бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлж, халдварт өвчингүй тайван байх нөхцөлийг хангана. |

| | |
|---|---|
| **5** | Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэх, эрэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно. |
| **6** | Орон нутгийн түүхий эд, нөөцөд түшиглэсэн дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. |
| **7** | Худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, шударга өрсөлдөөнийг бий болгоно. |

*Эх сурвалж: 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэл, аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” мөрийн хөтөлбөр*

1.4 Аймгийн Засаг дарга бүс нутгийн онцлог, нөхцөлд байдалд тулгуурлан, үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлаагүй, Мөн Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-аар аймаг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулаагүй[1], аймгийн ИТХ-аар батлуулаагүй[2] үндэсний хөтөлбөрийн зарим нэг заалтыг шууд хэрэгжүүлж ажилласан байна.

1.5 Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг бүрэн тодорхойлоогүй, үе шаттай, оновчтой төлөвлөөгүйгээс зорилтод заасан арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй, гол үр дүнг илтгэх хэрэгжилтийн ажлууд орхигдох эсвэл тайлагнахгүй байх, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заагдсан байгууллага бүрээр холбогдох газраас тайланг авч нэгтгэдэггүйгээс тайлан бодитой бус, үр дүнгээс илүү үйл ажиллагааг дараалуулан тоочдог, адил төстэй арга хэмжээний тайлангаар орлуулдаг, арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар нотлох баримтгүй, холбогдох мэргэжилтэн нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аудит хийх хугацаанд бичсэн байдлаар тайлагнаж байна.

1.6 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнсний аюулгүй байдлыг хангах талаар “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийг 1 томоохон зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байтал дээрх журмын 55.6[3] дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй, аймгийн ИТХ-аар батлуулаагүй байна.

1.7 Аймгийн Засаг дарга, аймгийн ИТХ “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулан, хөтөлбөрт суурилсан төсвийг төлөвлөн, санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангаж ажиллах ёстой боловч дээрх чиг үүргээ хэрэгжүүлээгүй, “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 5.4[4], 5.5[5] дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

[1] *11. Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг, төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг, төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага үндэсний хөтөлбөрийн төслийг, Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг тус тус боловсруулна.*

[2] *33. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.*

[3] *Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх*

[4] *Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” дэд хөтөлбөрийг баталж, санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжилтэд нь хяналт тавина.*

[5] *Аймаг, нийслэлийн Засаг дарга “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.*

1.8 Харин аймгийн ИТХ-аас хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийг баталсан байна.

*Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүдийн 2016-2020 оны хэрэгжилтийн тайлан*

*Хүснэгт №2*

| № | Хөтөлбөрийн нэр | Хэрэгжих хугацаа | Нийт | | Аймагт хэрэгжүүлэх | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зорилт | Арга хэмжээ | Зорилт | Арга хэмжээ |
| **Үндэсний хөтөлбөрүүд:** | | | | | | |
| **1** | Монгол мал | 2010-2021 | 5 | 81 | 4 | 8 |
| **2** | Ус | 2010-2021 | 6 | 91 | 1 | 3 |
| **3** | Эрүүл хүнс - Эрүүл монгол хүн | 2019-2023 | 5 | 48 | | |
| **4** | Малын эрүүл мэнд | 2018-2021 | 6 | 28 | 6 | 6 |
| **5** | Сав, баглаа боодол | 2017-2021 | 5 | 29 | 3 | 6 |
| **6** | Хүнсний ногоо | 2018-2022 | 4 | 32 | 4 | 32 |
| | **Дүн** | | **27** | **277** | **24** | **37** |
| **Аймгийн хөтөлбөрүүд:** | | | | | | |
| **1** | Булган жимс жимсгэнэ | 2017-2020 | - | - | 5 | 33 |
| | **Дүн** | | **-** | **-** | **5** | **33** |
| | **Нийт дүн** | | **27** | **277** | **38** | **112** |

*Эх сурвалж: Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүдийн 2016-2020 оны хэрэгжилтийн тайлан*

***Хүнсний салбарт мөрдөгдөж буй стандарт нь хүнсний аюулгүй байдалд бүх шалгуурыг хангаж байгаа ч зарим стандартуудыг шинэчлэн батлах шаардлагатай байна.***

1.9 Төрөөс баталсан хүнсний салбарын бодлого, авч буй арга хэмжээ түүний хэрэгжилтийг хангахад, хүнсний сүлжээний бүх үе шат дахь хүнсний чиглэлийн үйл ажиллагааны чанар аюулгүй байдлыг хангасан стандартууд зайлшгүй шаардлагатай байна. Харин аудитын явцад холбогдох байгууллагаас авсан судалгааны дүнгээс харахад дараах стандартууд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- *“Чацаргана жимс. Техникийн шаардлага” MNS 0916-2011 стандартын техникийн шаардлагад хүчиллэг Витамин С зэрэг гол үзүүлэлт байхгүй,*
- *“Усны чанар. Ундны усанд фтор ион тодорхойлох арга” MNS 6272:2011 Оксихлорид цирконил уусмалыг найруулах заавар алдаатай бичигдсэн,*
- *“Усны чанар. Манганын агууламжийг тодорхойлох арга” MNS 5790:2007 Жиших муруй байгуулахад стандарт уусмалуудад харгалзах концентрацийн утга тодорхой бичигдээгүй,*
- *“Халуун утлагат загас” MNS 2835:1978 Стандартад заасан шинжилгээний аргын "Хиам, махан бүтээгдэхүүнд хийх бактери судлалын шинжилгээний арга MNS 2553:78, махан консерв, хиамны мэдрэхүйн ба химийн шинжилгээний арга MNS 514:81 стандартууд хүчингүй болсон. Зөвхөн чанарын үзүүлэлтийг заасан, химийн болон бактериологийн, хүнд металлын үлдэгдэл буюу хор судлалын аюулгүйн үзүүлэлт, техникийн шаардлагын үзүүлэлт нэмэлтээр оруулж өгөх зайлшгүй шаардлагатай.*

***Хүнсний салбарт хэрэгжиж буй хууль, бусад актуудын хэрэгжилт хангалтгүйгээс хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлж байна.***

1.10 Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын бодлого, эрх зүйн орчин нь Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 1 дүгээр заалт “хүн амьд явах эрхтэй...” гэсэн суурь зарчим, Монгол Улсын нэгдэн орсон “Хүний эрхийн түгээмэл тунхаг”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн

талаар баримтлах бодлого, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актын хүрээнд бүрдэж байна.

1.11 Хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төрөөс баталсан хүнсний салбарын бодлого, авч буй арга хэмжээ, түүний хэрэгжилт, хүнсний хэрэглээний бүх үе шат дахь үйл ажиллагаа, түүнд тавих хяналт шалгалт болон хэрэглэгчийн сэтгэл ханамжаар илэрхийлэгддэг.

1.12 2006 онд батлагдсан "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "*хүнсний аюулгүй байдлыг хангах,....*" гэж аймгийн Засаг даргын бүрэн эрхийг тусгасан боловч энэ талаар хэрэгжүүлж, хийж гүйцэтгэсэн ажил хангалтгүй байна.

***Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах цогц зорилт хөтөлбөр хангалттай хэрэгжээгүй, бодит үр дүн гараагүй байна.***

1.13 Тухайн орон нутагт үндэсний хөтөлбөрийн ямар арга хэмжээг хэрэгжүүлэхийг тодорхой зааж өгөөгүйгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, хоорондын уялдаагүй, тодорхой үр дүнд хүрээгүй, зорилтоо биелүүлээгүй зорилгодоо хүрээгүй, хэрэгжилтийг бодитоор үнэлдэггүй нь аудитын явцад ирүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн баримт материалуудаас харагдаж байна. Тухайлбал:

- *Аудит хийх хугацаанд албан бичгээр болон шаардлагатай баримт материалын жагсаалтыг удаа дараа өгч, талбарт ажиллах хугацаанд шаардсан боловч 2018, 2019 оны хөтөлбөрийн биелэлтийг ирүүлээгүй,*
- *Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд ЗГҮАХ-т тусгагдсан зорилтод Жимс жимсгэнэ хөтөлбөрийн 1 заалт арга хэмжээнээс бусад үндэсний хөтөлбөрийн арга хэмжээ тусгагдаагүй,*
- *Хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл болон сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах арга хэмжээний хүрээнд сумын мэргэжилтнүүдэд хуванцар савны тэмдэг тэмдэглэгээний талаар сурталчилгааг цахимаар байнга хийж, орон нутгийн хэмжээнд "хуванцар савгүй сум баг" аяныг зохион байгуулж ажиллах чиглэлийг ХХААГ-ын даргын албан тоотоор үүрэг чиглэл өгч ажилласан боловч үүрэг даалгаврын тооцож ажиллаагүй,*
- *Хүнсний сав, баглаа боодолд тавих эрүүл ахуйн шаардлага өндөрсөж, бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодолтой харьцах хэрэглэгчдийн хандлага, сонголт өөрчлөгдөж, мэдлэг нэмэгдсэн, зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээ буурсан талаар суурь судалгаа хийгээгүй, үр дүнг тооцоогүй, хөтөлбөрийн зорилгодоо хүрээгүй,*
- *Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөрийн талаарх хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дурдагдаагүй,*
- *ХХААГ-ын мэргэжилтэн Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилтийг 100 хувь гэж тайлагнаснаас бусад үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд бодлогын түвшинд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ болон оролцоо байхгүй байгааг харуулж байна.*
- *Хяналт шинжилгээ үнэлгээ-дотоод аудитын хэлтсийн 2019 оны МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээнд "жимс жимсгэнэ" хөтөлбөрийн хүрээнд жимс жимсгэнийн тариалалтыг зорилтод түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг 8000 га, ургацыг 10000 тонн хүргэхээр*

*тусгасан болович тариалалт 715 га, ургац 28.6 тонн байхад бодит байдал дээр тариалалт 8.9 хувь, ургац 0.3 хувийн хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн байна.*

1.14 Аймгийн МХГ-ын хүнсний аюулгүй байдлын хяналтын 4 чиглэлээр 2018-2020 онд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг 4622 объектод хийж, 3682 зөрчлийг илрүүлж, 2654 буюу 72.1 хувийг арилгуулсан байна.

*Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын тоон мэдээлэл*

*Хүснэгт №3*

| № | Хяналт шалгалтын чиглэл | Шалгалтад хамрагдсан объектын тоо | | | Илэрсэн зөрчлийн тоо | | | Арилгуулсан зөрчлийн тоо | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 |
| **1** | Хүнсний чанар, стандарт | 592 | 607 | 705 | 208 | 406 | 367 | 144 | 315 | 278 |
| **2** | Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт | 592 | 607 | 705 | 421 | 487 | 438 | 287 | 311 | 299 |
| **3** | Мал эмнэлгийн хяналт | 154 | 154 | 117 | 169 | 139 | 141 | 134 | 99 | 105 |
| **4** | Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт | 125 | 136 | 128 | 346 | 285 | 275 | 248 | 208 | 226 |
| | **Дүн** | **1463** | **1504** | **1655** | **1144** | **1317** | **1221** | **813** | **933** | **908** |

*Эх сурвалж: Аймгийн МХГ-ын үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын мэдээлэл*

1.15 Хүснэгтээс харахад аймгийн МХГ-ын 2018-2019 онд хяналт шалгалтад хамрагдсан байгууллага, илэрсэн болон арилгуулсан зөрчлийн тоо өсөлттэй байсан бол 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаа явуулаагүй учраас төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийгдээгүй, үүнийг дагаад илрүүлсэн болон арилгуулсан зөрчлийн тоо өсөлттэй, бууралттай байгаа нь хяналтын онцлог, хамрагдсан обьектын тоо, шинээр нэмэгдсэн обьект, хууль, дүрэм, журам, стандарт, асуумжийн өөрчлөлт, эрсдлийн шалгуурын зөвлөмж зэргээс нөлөөлсөн байна.

1.16 Хэдийгээр тус байгууллага нь хуулийн хэрэгжилтийг хангуулахаар хяналт шалгалтыг эрсдэлд суурилан жил бүр тогтмол хийж байгаа болович гарч байгаа зөрчлийн тоо буурахгүй тогтмол өсөж байгаа нь хяналт шалгалт үр нөлөөгүй, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хэрэгжиж байгаа хууль, эрхийн актуудын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

***Төр болон төрийн бус байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй байна.***

1.17 Төрийн болон төрийн бус байгууллага мэргэжлийн байгууллагууд хамтран иргэд, олон нийтийн дунд хүнсний аюулгүй байдлын талаар зөвхөн сургалт, сурталчилгаа, мэргэжлийн тэмцээн уралдаан явуулж байгаа нь төр болон төрийн бус байгууллагуудын хоорондын хязгаарлагдмал, уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

1.18 Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3[6], 14[7] дүгээр зүйлд заасны дагуу хүнсний чиглэлийн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын зүгээс хөндлөнгийн болон олон нийтийн хяналт тавьсан, хэрэглэгч болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа

[6] *Хуульд заасан хүрээ, хязгаарын дотор мэргэжлийн холбоо болон бусад төрийн бус байгууллага, иргэн хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно*

[7] *Төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангахад дараах чиглэлээр оролцоно:*
*14.1.1.хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;*
*14.1.2.хэрэглэгч болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрхийг хамгаалах асуудлаар саналаа төрийн болон нутгийн захиргааны байгууллагад уламжлах;*
*14.1.3.хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хооллолтыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;*
*14.1.4.хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдох судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх.*

эрхлэгчийн эрхийг хамгаалах асуудлаар санал уламжилсан талаарх тайлан, мэдээ, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хийгдсэн судалгаа байхгүй байна.

***Төрийн байгууллагуудын чиг үүрэг давхардсан, зарим чиг үүрэг орхигдсон байна.***

1.19 Орон нутагт хүнсний аюулгүй байдлыг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3[8], 29.1.3.а[9]-д тодорхойлсны дагуу хүнсний талаарх бодлого, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
1.20 Орон нутагт хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байгаа байгууллагуудын хамтын ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг харуулбал дараах байдалтай байна.

*Бүдүүвч №1*




1.21 Дээрх схемээс харахад орон нутгийн түвшинд хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй эрх бүхий байгууллагууд нь ажлын уялдаагүй, нэгдсэн удирдлага зохицуулалтгүй байна.

1.22 Мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлж байгаа аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газрын улсын байцаагчдад хууль, эрх зүйн хүрээнд дараах давхцалууд үүсэж байна. Үүнд: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хуулийн 31.1 дэх заасны дагуу Мал эмнэлгийг газар сумдын байцаагч нь “Мал эмнэлгийн улсын байцаагч” гэсэн нэршилтэйгээр мал эмнэлгийн байгууллагынхаа үйл ажиллагааны хяналтыг, Мэргэжлийн хяналтын газрын аймаг, сумдын байцаагч “Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч” гэсэн нэршилтэйгээр хөндлөнгийн хяналтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.23 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2, 31.3.3 дахь заалтуудад тусгагдсан үйл ажиллагаатай холбоотой хяналтууд Мэргэжлийн хяналтын байцаагчийн бүрэн эрхэд хамаарч байгаа бол мал эмнэлгийн байгууллагын улсын байцаагчид салбарын үйл ажиллагаатай холбоотой хяналтыг бүрэн хэрэгжүүлэх эрх олгогдоогүй байна.

***Төрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн гүйцэтгэж зөрчлийг засаж залруулсан гүйцэтгэлийн биелэлт дунджаар 73.5 хувьтай байна.***

1.24 УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.11[10] дэх заалттай холбоотой хүнсээр дамжуулан хүний

---

[8] Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, газар, байгалийн бусад баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах талаар:
[9] төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;
[10] Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, зөрчилтэй эвлэрсэн ойлголт, хандлагыг өөрчлөх, тавигдах шаардлагыг өндөрсгөх, нутгийн

эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдол аймгийн хэмжээгээр гарч байсан тоо баримт мэдээлэл байхгүй байна.

1.25 МХГ хүнсний чанар, стандартын хяналт, хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтыг аюулгүй байдалд хийсэн хяналт шалгалтаар 2016-2020 онд дунджаар 44.8 объектыг хамруулж хүнсний тухай хууль, тогтоомж зөрчсөн иргэд, аж ахуй нэгжид тухай бүр зөрчлийг арилгах акт, албан шаардлага хүргүүлснээс биелэлтийн хувь дунджаар 73.5 хувьтай, мөн биелэлтийн хэрэгжилтийг тооцохдоо зөвхөн ирүүлсэн албан тоотоор тооцдог нь зөрчлийг засаж залруулах ажил хангалтгүй байгааг харуулж байна.

***Мэргэжлийн байгууллагын чиг үүрэг зохион байгуулалт оновчтой зайлшгүй хийх шаардлагатай судалгаа шинжилгээг тогтмол хийдэггүй байна.***

1.26 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар тогтоолоор захирамжаар "Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл"-ийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зөвлөлийн ажиллах журам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

1.27 Гамшгаас хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайлантай танилцахад хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын дохиолдол, онцгой нөхцөл байдал, хямрал үүсэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, ажил тусгагдаагүй, шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байгаа нь хамтран хэрэгжүүлэх байгууллага хоорондын уялдаа, хамтын ажиллагаа зохицуулалтгүйг илэрхийлж байна.

***Аймгийн стратегийн улирлын нөөцийн бүрдүүлэлтийн талаарх баримтыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, стратегийн нөөцийг бүрдүүлэх, зарцуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.***

1.28 Булган аймгийн стратегийн улирлын нөөцийн хүнсийг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээс зөвхөн махыг тодорхойлсон бөгөөд холбогдох тооцоолол, судалгааг хийгээгүй нь Хүнсний тухай хуулийн 6.2[11]-д заасан эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой байна.

1.29 Аймгийн Засаг даргад Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.5 дахь заалтыг үндэслэн албан тоотоор аудитад шаардлагатай баримт, материалыг удаа дараа шаардсан боловч аймгийн ЗДТГ-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 03/1194 албан тоотоор зарим баримт материалыг хангалтгүй ирүүлсэн. Аудитын хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн үе шатны ажил дуусгавар болсон тул ирүүлсэн баримтад дүн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх боломжгүй гэж үзлээ.

***Лабораториудын хүчин чадал, хүний нөөц, шинжилгээ хийхэд шаардлагатай түүхий эдийн хангамж болон хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдэд хийгдэж буй лабораторийн шинжилгээний тоо мэдээлэлд харьцуулалт хийх замаар өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй байна.***

1.30 Аймгийн хэмжээнд итгэмжлэгдсэн МХГ болон МЭГ-ын төрийн хоёр лаборатори хүнсний бүтээгдэхүүний дээжид шинжилгээг батлагдсан орон тооны дагуу 1 эрхлэгч, 3 шинжээч эмч, 1 дээж бүртгэгч албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжилтэй, 2-20 жил ажилласан ажилтан ажиллаж байна. МХЕГ-ын ХАБҮЛЛ болон бусад байгууллагаас

---

захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй арга хэлбэрийг хэвшүүлэх

[11] *Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.*

зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад 1-2 жил тутам хамрагдаж, МЭГ-ын лабораторийн ажилчид 2020 оны байдлаар 9 сургалтад давхардсан тоогоор 19 албан хаагчийг хамруулсан байна.

1.31 Стандарт хэмжил зүйн газрын даргын 2016 оны А/147, 2019 оны А/302 тоот тушаалаар МХГ-ын, 2017 оны А/379, Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2021 оны А/124 дүгээр тушаалаар МЭГ-ын лабораторийн хүчин чадал буюу шинжлэгдэх бүтээгдэхүүний үзүүлэлтүүдийг тодорхойлж өгчээ.

1.32 МХГ-ын лабораторийн 2016-2020 оны гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дээжид, МЭГ-ийн лаборатори 2019-2020 онд хийсэн дээжийн үзүүлэлтийг итгэмжлэлийн хүрээнд харьцуулан үзэхэд МХГ 12-25, МЭГ 49-75 хувийн үзүүлэлтээр дээжид шинжилгээ хийсэн байна.

Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн 2016-2020 оны хүнсний бүтээгдэхүүний дээжийн дундаж үзүүлэлтийг итгэмжлэлийн үзүүлэлтийн харьцуулалт

*/Хүснэгт 4/*

| № | Гол нэрийн бүтээгдэхүүн | Итгэмжлэлээр | | Дундаж үзүүлэлт | | | | | Харьцуулсан үзүүлэлт % | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2016 оны А/147 | 2019 оны А/302 | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он |
| 1 | Мах махан бүтээгдэхүүн | 25 | 35 | 1.9 | 2.7 | 3.1 | 2.7 | 2.8 | 7.7 | 10.8 | 12.6 | 7.6 | 8.0 |
| 2 | Сүү | 21 | 17 | 0.0 | 0.0 | 2.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 9.5 | 0.0 | 0.0 |
| 3 | Сүүн бүтээгдэхүүн | 35 | 29 | 5.6 | 10.5 | 2.4 | 9.4 | 2.1 | 16.1 | 30.0 | 6.8 | 32.4 | 7.3 |
| 4 | Гурил | 22 | 24 | 4.2 | 6.4 | 5.7 | 2.3 | 1.3 | 18.9 | 28.9 | 26.1 | 9.7 | 5.3 |
| 5 | Гурилан бүтээгдэхүүн | 17 | 16 | 4.2 | 4.4 | 4.3 | 3.1 | 2.3 | 24.8 | 26.0 | 25.3 | 19.5 | 14.4 |
| 6 | Төрөл бүрийн будаа | 9 | 11 | 3.4 | 5.7 | 3.0 | 2.7 | 0.0 | 37.8 | 63.4 | 32.8 | 24.2 | 0.0 |
| 7 | Сахар, чихрийн зүйл | 37 | 36 | 7.9 | 11.5 | 6.6 | 9.1 | 0.0 | 21.4 | 31.1 | 17.9 | 25.2 | 0.0 |
| 8 | Төмс | 12 | 13 | 9.3 | 2.8 | 4.1 | 2.6 | 2.4 | 77.1 | 23.4 | 34.0 | 20.2 | 18.3 |
| 9 | Хүнсний ногоо | 10 | 11 | 1.5 | 3.6 | 4.1 | 2.0 | 2.0 | 15.4 | 35.5 | 41.2 | 18.1 | 17.8 |
| 10 | Жимс, жимсгэнэ | 18 | 11 | 5.5 | 4.3 | 7.5 | 5.7 | 4.5 | 30.6 | 24.0 | 41.6 | 52.3 | 40.5 |
| 11 | Буурцагт ургамал | 0 | 2 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 12 | Өндөг | 15 | 7 | 0.0 | 5.2 | 3.0 | 3.7 | 2.8 | 0.0 | 34.7 | 20.0 | 52.4 | 39.3 |
| 13 | Хүнсний тос | 10 | 10 | 9.0 | 0.0 | 1.0 | 3.5 | 1.0 | 90.0 | 0.0 | 10.0 | 35.0 | 10.0 |
| 14 | Ундны ус | 22 | 22 | 1.0 | 7.7 | 4.7 | 4.2 | 0.0 | 4.5 | 35.0 | 21.4 | 19.0 | 0.0 |
| 15 | Үр тариа, бусад үрсэлгээ | 14 | 15 | 4.6 | 3.1 | 5.3 | 3.7 | 1.8 | 32.8 | 22.4 | 37.9 | 24.4 | 11.7 |
| **Нийт үзүүлэлт** | | **267.0** | **259.0** | **58.1** | **67.9** | **56.8** | **54.6** | **22.8** | | | | | |
| **Дундаж үзүүлэлт** | | **17.8** | **17.3** | **3.9** | **4.5** | **3.8** | **3.6** | **1.5** | **25.1** | **24.3** | **22.5** | **22.7** | **11.5** |

*Эх сурвалж: Лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн сангийн маягтаас дундаж үзүүлэлтийг тооцоолсон болно.*

Мал эмнэлгийн лабораторийн 2019-2020 оны итгэмжлэлийн үзүүлэлтийн харьцуулалт

*/Хүснэгт 5/*

| *№* | *Гүйцэтгэж байгаа сорилтын төрөл* | *Итгэмжлэлийн эрчилгээ* | | *Үзүүлэлтээр* | | *Харьцуулсан үзүүлэлт %* | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | *2017 оны А/379* | *2021 оны А/124* | *2019 он* | *2020 он* | *2019 он* | *2020 он* |
| 1 | Нян судлал | 15 | 17 | 8 | 8 | 53.3 | 53.3 |
| 2 | Ийлдэс судлал | 6 | 7 | 2 | 6 | 33.3 | 100.0 |
| 3 | Паразит судлал | 6 | 5 | 5 | 8 | 83.3 | 133.3 |
| 4 | Ариун цэврийн шинжилгээ | 29 | 44 | 22 | 26 | 75.9 | 89.7 |
| 5 | Молекул биологийн шинжилгээ | | 8 | 0 | 0 | 0.0 | 0.0 |
| ***Нийт үзүүлэлт*** | | ***56*** | ***81*** | ***37*** | ***48*** | ***245.9*** | ***376.3*** |
| ***Дундаж үзүүлэлт*** | | ***14*** | ***16.2*** | ***7.4*** | ***9.6*** | ***49.2*** | ***75.3*** |

*Эх сурвалж: Мал эмнэлгийн газрын лабораторийн 2019-2020 оны дүнгийн хуудас /дээжийн бүртгэл/-аар тооцоолов.*

1.33 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинжилгээний гүйцэтгэл жил бүр хангалттай гэж дүгнэсэн ч лабораториуд бүрэн хүчин чадлаар ажиллаагүй буюу дээжийг тодорхой хэд хэдэн үзүүлэлтээр шинжилж байна.

1.34 Холбогдох эрхлэгч, мэргэжилтнээс лаборатори бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байгаа шалтгааныг тодруулахад:

- *Тоног төхөөрөмж дутмаг,*
- *Мэргэшсэн сургалтад хамрагдаагүй,*
- *Хүний нөөц дутмаг,*
- *Орчин нөхцөл, барилга байгууламж шаардлага хангахгүйгээс нөлөөлжээ.*

1.35 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тодорхой хэмжээний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэл хангаж байна. Орон нутгийн хувьд мал аж ахуй голлох үүрэгтэй ч хүнсэнд хэрэглэж буй мах бүрэн шинжилгээнд хамрагдаж чадахгүй байна. Тухайлбал:

- *Статистикийн хэлтсийн мэдээгээр 2019 онд нийт 1024.4 мянган малыг хэрэглэснээс 822.8 мянган малыг зах зээлд борлуулсан байна. Гэвч МЭГ-ийн лабораторид тус онд нийт 205 дээж ирж шинжлүүлэн бүгд сөрөг гарчээ. Өөрөөр хэлбэл 0.02 хувь малын мах шинжилгээнд хамрагдсан байна. Уг дээжийн 99 хувь нь Булган сумын харьяаны иргэд, ААНБ, үлдсэн 1 хувийг сумаас ирүүлжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/*

1.36 МЭГ-ийн лабораторид 2020 онд махны 208, сүүний 41 дээж ирж шинжилгээнд хамрагдан тэнцээгүй дээж гараагүй байна. Хавсралт 2-оос *үзнэ үү.*

1.37 “Малын эмийн үлдэгдэл” үндэсний хөтөлбөрийг баталсны дагуу МЭГ-ийн лаборатори 2020 онд малын эмийн үлдэгдэл тодорхойлох 34 махны, 46 сүүний дээжид шинжилгээг хийжээ. Шинжилгээнд хамрагдсан мах, сүүний дээжийн хариунд эерэг буюу тэнцээгүй дээж гараагүй байна.

1.38 Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2021 оны А/124 тоот тушаалаар Итгэмжлэлийн хүрээнд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох үзүүлэлтийг баталж өгчээ. Антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг 2020 онд итгэмжлэлд ороогүй үзүүлэлтээр шинжилгээг хийсэн нь Мал, амьтны эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1-д “итгэмжлэлийн хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ хийх, мал, амьтны өвчнийг оношлох” гэж заасныг зөрчсөн байна.

1.39 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2[12], 10 дугаар зүйлийн 10.1.2[13]-т заасны дагуу лабораторийн шинжилгээнд мах, махан бүтээгдэхүүнээр үйлчилдэг худалдаа, үйлчилгээ эрхлэгч хувь хүн, хуулийн этгээд бүрэн хамрагдахгүй байна.

1.40 ХХААГ-ын мэргэжилтний хийсэн судалгаагаар Булган аймагт 2020 оны байдлаар хүнсний чиглэлийн 55 худалдааны томоохон төв, зах, 11 үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж байна. МХГ-ын лабораторид 2020 онд хүнсний бүтээгдэхүүний 1474 дээж шинжилгээнд хамрагдаж, 174 буюу 11.8 хувь нь эерэг буюу тэнцээгүй дээж ээлжээ. *Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү.*

1.41 Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна. Тухайлбал:

- *МХГ-ын лаборатори өөрийн онцлогт уялдуулсан программ 2020 оноос бүрэн нэвтрүүлсэн тул 2016-2019 оны нийт дээж болон дээжид хийсэн үзүүлэлтийн тоо зөрүүтэй,*
- *МЭГ-ын лабораторийн программаас дээжийн бүртгэл, нэгтгэлд боловсруулалт хийхэд ирсэн дээжийн нийт үзүүлэлт гардаггүй, улирлаар мэдээлэл гарч жилийн эцэст шинжээч эмч нар гар аргаар тооцоолол хийж мэдээ тайланг гаргадаг,*

[12] *“хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал”*
[13] *“энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэрэгжүүлэх”*

- *Итгэмжлэлийн тодорхойлолтод тусгагдаагүй ч мах, сүүнд эмийн үлдэгдэл буюу антибиотикийн үлдэгдлийн шинжилгээг 2020 оноос хийж эхэлсэн, уг шинжилгээг хийх шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг,*
- *МЭГ-ийн шинжилгээнд ирж буй дээжийн хариу, бүртгэлийг шинжээч эмч нар бүрэн харах боломжтой байгаа нь хараат бус байдал алдагдах, шинжилгээ үнэ зөв гарахгүй байх,*
- *ЭМГ-аас СӨБ, ЕБС-ын хувьд албан ёсны батлагдсан үнэлгээний хуудас байхгүй бөгөөд МХГ-ын шалгуур үнэлгээний хуудсыг үндэслэн хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн ЕБС-д 7, СӨБ-д 19 заалт бүхий үнэлгээний хуудас боловсруулж цэцэрлэгийн дундаж 87.3, ЕБС-ийн дундаж 82.5 хувьтай үнэлэгджээ. Гэвч зөвлөн тусалснаар ямар үр дүнд хүрсэн, алдаа зөрчил хэр хэмжээнд буурсан, хоол тэжээлийн хэмжээ зохистой хэмжээнд байгаа эсэх, тандалт судалгаа хийгээгүй байна. Мөн хоол тэжээлийн илчлэгийг МХГ-ийн лабораторид байгууллагууд хүргүүлж тодорхойлуулдаг ч стандарт хэмжээнд нийцэж буй эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.*

***Хүнсний хангамжийн бодлогын хүрээнд хийж буй ажлууд үр дүн муутай, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл хангалтгүй, зарим хүнсний бүтээгдэхүүн импортын хамааралтай байна.***

1.42 Орон нутагт хүнсний чиглэлээр батлагдсан 5 үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зорилтын биелэлт 93-100 хувьтай бөгөөд хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээг үнэлээгүй, хүрсэн үр дүнг тооцоогүй байгаа нь Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг оновчтой зохион байгуулаагүй, үр дүн муутай байна.

1.43 Нэг хүнд ногдох хүнсний хэрэглээ болон илчлэг, уураг, өөх тос, нүүрс усны хэмжээг улсын дундаж, хот, хөдөөгөөр, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалаар жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ, хангамжийг улсын хэмжээнд тооцон гаргаж байна.

1.44 Хүн амын хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээлийн болон чанар, эрүүл ахуйн үзүүлэлт албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт боловч Статистикийн хэлтэс аймаг, сумын хэмжээнд уг үзүүлэлтийг тооцон гаргадаггүй байна.

1.45 ХХААГ-ын мэргэжилтэн орон нутгийн хүн амын хүнсний хангамжийг ЭМС-ын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу тооцоололд гол нэрийн 16 бүтээгдэхүүнээс 2018 онд 3, 2019 онд 3, 2020 онд 3 бүтээгдэхүүн дотоодын хэрэгцээг бүрэн хангах, үлдсэн 13 нэрийн бүтээгдэхүүн 81.3 хувийг бусад Улаанбаатар хот, болон зэргэлдээ аймгаас нийлүүлэгдэж байна. Экспорт, импортын бүтээгдэхүүний судалгаа, тооцоолол хийгдээгүй болно. *Хавсралт 4-өөс үзнэ үү.*

1.46 Гэвч уг тооцооллыг хийхдээ бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна. Тухайлбал:

- *Өмнөх оны статистик хүн амын тоог жишсэн хүн амд шилжүүлж,*
- *Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоон мэдээлэл нь статистикийн тоон мэдээлэл бус сум, орон нутагт ажиллаж буй хөдөө аж ахуйн мэргэжилтнээс нотлох баримтгүй аман мэдээллээр цуглуулсан,*
- *Төрөл бүрийн будаа 2018, 2020 онд 0.4, 1.9 хувь, 2019 онд 2067.9 хувийг хангаж байгаагаар тооцоологдсон нь Хутаг-Өндөр, Орхон зэрэг сумын мэргэжилтнүүд мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс “0” гэж үзэн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тооцоолол хийсэн,*
- *2018 оны тооцооллыг хүчингүй болсон ЭМС-ын 2008 оны 257 дугаар тушаалаар тооцоолсон,*
- *Махыг тооцохдоо холбогдох журмыг зөрчин ястай махаар тооцсон байна.*

1.47 Орон нутаг дахь хүн амын хүнсний хэрэгцээ, хангамжийг тооцоолдоггүй, нийт үйлдвэрлэл, хэрэглээ, хэрэгцээг холбогдох мэргэжлийн байгууллага буюу ХХААГ-аас

нотлох баримтгүй, бодит бус мэдээлэлд үндэслэн тооцоолол хийсэн нь иргэд, олон нийт, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллаагүй байна.

***Хүнсний сүлжээний бүртгэл, хяналт баталгаажуулалт үр нөлөөгүй байна.***

1.48 Мэргэжлийн хяналтын газар 2016-2020 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хүнсний чанар, стандартын хяналтыг нийт объектын 9 хувь, хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтыг 7 хувийн дундажтай гүйцэтгэсэн бөгөөд алдаа зөрчлийн биелэлт 67-75 хувьтай байна. *Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/*

1.49 Стандарт хэмжил зүйн хэлтэс 2018-2020 онд дунджаар 32 бүтээгдэхүүн, 217 үйлчилгээг баталгаажуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр бүтээгдэхүүн 53 хувь, үйлчилгээ 94 хувьтай байна. *Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас үзнэ үү.*

1.50 Орон нутагт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэгч аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, иргэдийн тоон мэдээллийг харьцуулах, дүн шинжилгээ хийх боломжгүй байгаа нь төрийн байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүд ажлын уялдаа холбоогүй ажилладгаас шалтгаалж байна. Тухайлбал:

- *Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ, иргэд, хоршооны тоо зөрүүтэй,*
- *Статистик мэдээний зарим үзүүлэлт тусгагдаагүйгээс харьцуулах боломжгүй,*

1.51 Аудитын гүйцэтгэлийн шатанд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагаас 7 ААНБ-ын үйл ажиллагаанд түүвэрлэн стандарт болон хуулийн хэрэгжилттэй танилцахад дараах зөрчил илэрлээ. /*Зургийг хавсралт 8-аас үзнэ үү/* Тухайлбал:

- *Гарал үүслийн бичиггүй мал борлуулдаг,*
- *Шинжилгээний бичиггүй болон шинжилгээний нэг бичгээр мах, сүү борлуулдаг,*
- *Тохирлын үнэлгээнд хамрагдаагүй үйлдвэрлэгч үйл ажиллагаа явуулдаг, бүтээгдэхүүний шинжилгээний бичгээр борлуулалт хийдэг,*
- *Стандартын бус агуулах, байранд хүнсний түүхий эд болон бүтээгдэхүүнийг хадгалдаг,*
- *Стандартын шаардлага хангаагүй сав, баглаа боодолд хүнсний бүтээгдэхүүн савалдаг,*
- *Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг тухай бүр хөтөлдөггүй,*
- *Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээж авахдаа шинжилгээний бичгийг тухай бүр авдаггүй, шаарддаггүй,*
- *Хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, шинжилгээний бичиг, хаяг шошго, хугацааг төдийлөн анхаардаггүй,*
- *Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагын ажилчид мэргэжлийн бус, зориулалтын ажлын хувцасгүй, эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй,*
- *Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд тавьж буй дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байна.*

1.52 Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1[14], 13 дугаар зүйлийн 13.1.2[15], Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1[16], 10 дугаар зүйлийн 10.1.2[17], 10.1.6[18], 10.1.7[19], 12 дугаар зүйлийн 12.1[20], 18 дугаар зүйлийн 18.1.2[21],

[14] *Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна,*
[15] *Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт,*
[16] *Хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах,*
[17] *Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэрэгжүүлэх", 10.1.3[17]-т "энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх,*
[18] *Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах,*

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1[22], 13.2[23], 15 дугаар зүйлийн 15.6[24]-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд МХГ болон СХЗХ-т уг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

***Аймгийн хэмжээнд хүнсний сүлжээний бүх үе шатанд нэгдсэн хяналт, бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байна.***

1.53 Аймгийн хэмжээнд Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтыг төлөвлөдөг " http://www.khyanalt.gov.mn/ "Мал эмнэлгийн газар малын халдварт өвчний тандалт судалгааны "http://sur.shinjilgee.mn/", мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, ариун цэвэр, эрүүл ахуйг баталгаажуулах, лаборатори шинжилгээний "vetlab.shin", малыг ээмэгжүүлэх "https://www.vet.certificate.mn/login", Хүнс хөдөө аж ахуйн газар малын удмын сангийн мэдээллийн систем зэрэг хяналт, шинжилгээ, бүртгэл мэдээллийн систем ашиглаж байна.

1.54 Мал эмнэлгийн газарт ашиглагдаж байгаа "https://www.vet.certificate.mn/login" нэгдсэн бүртгэлийн систем нь ҮСХ-ны дата серверээс статистик мэдээллийг шууд татдаг бөгөөд тухайн мэдээллийн дагуу малын удмын сан, халдварт өвчний судалгаа тандалтыг хийхэд мэдээлэл зөрүүтэй, тухайн мал байршилдаа байхгүй зэрэг хүндрэлтэй асуудал үүсдэг тул мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн үнэн зөв байдалд холбогдох байгууллагууд уялдаа холбоотой ажиллах шаардлагатай байна.

1.55 "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан "Эрүүл хүнс-эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрт хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангаг, хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилготой хүнсний боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бүрдүүлсэн, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн бүртгэл, цахим мэдээллийн тогтолцоог бий болгоно гэж заасан боловч орон нутгийн хувьд нэгдсэн цахим мэдээллийн систем бий болоогүй байна.

***Аймгийн хэмжээнд инновац нэвтрүүлсэн, шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрөл байхгүй байна.***

1.56 "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5.5[25], Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 1.3.1[26] ,1.4.3[27], 4.1.2.[28], 4.1.13[29]

---

*[19] Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах,*

*[20] Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна,*

*[21] "хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх,*

*[22] Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино,*

*[23] Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна,*

*[24] Тохирлын үнэлгээний байгууллага дараах эрх, үүрэгтэй, 15.6.1-д тохирлын үнэлгээний үр дүнг үндэслэн тайлан гаргах, тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох*

[25] Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно.

[26] хүн амыг шим тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангасан байх;

[27] мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эд, байгалийн баялгийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангах;

[28] эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих,

[29] шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд турших, нэвтрүүлэх;

гэж заа, орон нутгийн хэмжээнд шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг тус тус тусгасан байна.

1.57 Хэдийгээр үндэсний хэмжээнд дээрх бодлого хэрэгжиж байгаа боловч аймгийн түвшинд бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.Тухайлбал:

- Малчид, тариаланчид органик арга, зарчмын талаар, мэдлэг мэдээлэл хомс, тэдэнд зөвлөн туслах үйлчилгээ хүрэхгүй,
- Хэрэглэгчдийн органик хүнсний талаарх мэдлэг, ойлголт муугаас “Органик” гэсэн үгийн маркетингийн үнэ цэнийг ашиглан, баталгаажилт хийгээгүй бүтээгдэхүүний шошгод “органик”, “байгалийн гаралтай цэвэр”, “байгалийн гаралтай” гэсэн мэдэгдлийг хийж, хэрэглэгчдийг төөрөгдүүлэн, хуурамч бүтээгдэхүүн хэрэглэж байна.

Иймд аймгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн инновац нэвтрүүлсэн, шим тэжээллэг болон органик хүнсний чиглэлээр сургалт, олон нийтэд хандсан сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг үнэлэх, ажиллах шаардлагатай байна.

***Хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэгдэж буй сав баглаа боодол, хаяг шошгод тавих хяналтын тогтолцоо байхгүй, хяналтын үйл ажиллагааны үр дүнд тодорхой үр дүн гараагүй, тодорхой стандартыг мөрдүүлээгүй байна.***

1.58 “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018-2020 онд 3 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж гүйцэтгэлээр 3 зорилтын 6 арга хэмжээг нийт 91.8 хувийн биелэлттэй тайлагнасан ч хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй, хүрсэн үр дүнг тооцоогүй байна.

1.59 Дээр дурдсан түүвэр тулгалтаар хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодолд лабораторийн шинжилгээ хийгдээгүй, хаяг, шошго тодорхойгүй, үйлдвэрлэсэн огноо байхгүй, үндсэн түүхий эдийн химийн олон улсын нэршил, тэмдэглэгээ байхгүй зэрэг нь сав, баглаа боодол, хаяг шошгод тавьж буй хяналт сул байна.

***Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох сайжруулах чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч үр дүнгүй байна.***

1.60 “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.18[30]-д заасны дагуу аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын зүгээс иргэдэд зориулан хүнсний зохистой хэрэглээ, эрүүл, зөв хооллох мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх, хүнсний бүтээгдэхүүний шошго дээрх мэдээллийг ашиглан хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон хэрэглэх, өдөр тутмын идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх талаар сургалт, сурталчилгаа хийсэн байна. *Хавсралт 7-оос үзнэ үү.*

1.61 Гэвч иргэдэд сургалт, сурталчилгааны талаарх мэдээллийн ажлыг хийж байгаа боловч хүнсний зохистой хэрэглээ, эрүүл, зөв хооллох мэдлэг, хандлага дадал, төлөвшсөн эсэх, хүнсний зохисгүй хэрэглээ, мэдээллээр бүрэн хангагдсан

---

[30] хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх

эсэхэд хийсэн судалгаа, үнэлэлт өгсөн ажил байхгүй, мөн хүнсний аюулгүй байдал алдагдсанаас үүсэлтэй өвчлөлийн талаарх судалгаа, мэдээлэл байхгүй байна.

1.62 Иймд цаашид иргэдийн хүнсний аюулгүй байдал, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлийг түвшинг тогтоох тандалт судалгаа хийх, түүн дээр үндэслэн сургалт, сурталчилгааг төлөвлөж байх шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2 Орон нутагт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал хуваариладаггүйгээс арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байна.

***Хөтөлбөрүүдэд суурилан төсвийг шаардлагатай хэмжээгээр бүрэн төлөвлөөгүй байна.***

2.1 Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж, аймгийн ИТХ-ын 2017 оны VI хуралдааны 06/06 дугаар тогтоолоор 370,000.0 мянган төгрөгийг баталсан байна.

2.2 Үндэсний болон аймгаас баталсан хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудад шаардлагатай хөрөнгө, санхүү, нөөцийг төлөвлөж, баталж өгдөггүйгээс шалтгаалан хөтөлбөр бүрэн хэрэгжихгүй байдалд хүрсэн. Цаашид үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг төсөвлөж өгөх шаардлагатай байна.

2.3 “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018 онд Засаг даргын нөөц сангаас үйл ажиллагааны зардалд 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулснаас өөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардал хуваарилаагүй байна.

***Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч үндэсний хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө гаргах шийдвэр гаргаагүй байна.***

2.4 Булган жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөрийг 2017-2018 онд 1,159,131.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр баталсан байна.

*Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2017-2018 онд хөтөлбөрүүдэд хуваарилсан зардал*

*Хүснэгт №6*

| № | Он | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол | Зардлын зориулалт | Баталсан /мянган төгрөг/ | Гүйцэтгэл /мянган төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2018 | 2017.02.17 №25 | Чацарганын суулгацын үнэ | 361,726.1 | 277,313.8 |
| 2 | | | 2017 оны намрын тариалалтаар олгосон суулгацын амьдралтын хувийг тооцож, дүгнэлт гаргах ажлын хэсгийн шатахуун, томилолтын зардал | 523.9 | 523.9 |
| 3 | | | Жимсний модны нүх ухагч техник | 5,750.0 | 5,750.0 |
| 4 | | | Иргэнд хашаа барихад зориулж төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон | 2,000.0 | 2,000.0 |
| **Дүн** | | | | **370,000.0** | **285,587.7** |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2017-2020 оны тогтоол*

2.5 “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018 онд Засаг даргын нөөц сангаас үйл ажиллагааны зардалд 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулснаас өөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардал хуваарилаагүй байна.

***Төсвийн гүйцэтгэлд хяналт хийгдээгүй учир үр дүнг тооцох боломжгүй байна.***

2.6 “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт аудитын албанаас тайлант хугацаанд хяналт шалгалт хийгдээгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

**Санал дэгсөн тайлбар**:

Аймгийн Засаг даргаас 4, МХГ-аас 13, МЭГ-аас 3, СХЗХ-ээс 1 санал, тайлбарыг аудитын баг нягтлан үзэж Засаг даргын 1, МХГ-ын 5, саналыг хүлээн авч тайланд зохих найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд 17 саналыг хүлээн авах боломжгүй тул дараах тайлбарыг өгч байна.

| | Санал өгөх тайлбар |
|---|---|
| ***БуААГ-ын тайлбар 1*** | *Манай 239 тоот балбан бичгийг бичиг хэргийн ажилтан 09 дүгээр сарын 29-ний өдөр гарын үсэг зурж хүлээн авсан, холбогдох хэлтэст хүрээгүй асуудал байгууллагын дотоод зохион байгуулалт бөгөөд тайлбар тул хүлээн авах боломжгүй байна.* |
| ***БуААГ-ын тайлбар 2*** | *Тайлангийн 13 дугаар хуудасны 32 дахь мөрийн өгүүлбэрийг аудитын багийн шийдвэрээр хасав.* |
| ***БуААГ-ын тайлбар 3*** | *Тайлангийн 16 дугаар хуудасны 24 дэх мөрний “Хүн амын хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээлийн болон чанар, эрүүл ахуйн үзүүлэлт албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт аймаг сумын хэмжээнд тооцон гаргадаггүй” гэсэн нь улсын хэмжээнд нэгтгэдэн гардаг гэсэн үгтэй утгын хувьд адилхан тул хэвээр үлдээсэн.* |
| ***БуААГ-ын тайлбар 4*** | *Тайланд уг асуудлын талаар тооцоолол алдаатай, бодит бус мэдээ, мэдээлэлд үндэслэн гарсан талаар дурдсан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.* |
| ***БуААГ-ын тайлбар 5*** | *Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасны дагуу МХЕГ-ын даргын 2014 оны 79 дүгээр тушаалаар бүртгэл хөтлөх аргачлал батлагдсан бөгөөд уг тушаал хүчин төгөлдөр тул зөвлөмжийг хэвээр үлдээх.* |
| ***БуААГ-ын тайлбар 6*** | *Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн засаж сайжруулах, арилгах арга хэмжээ авч ажиллах ч МХГ түүний биелэлтийг хянах, үнэлэлт өгөх тул уг саналыг хүлээн авах боломжгүй байна.* |
| ***БуААГ-ын тайлбар 7*** | *Албан шаардлагын агуулгатай давхцаж байгаа учир аудитын багийн шийдвэрээр хасав.* |
| ***БуААГ-ын тайлбар 8*** | *Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааг тайлбарт дурдсан ч бодит байдалд үр дүн хангалтгүй байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй болно.* |
| ***БуААГ-ын тайлбар 9*** | *Холбогдох байгууллагуудтай тодорхой арга хэмжээний асуудлын хүрээнд хамтарч ажиллаж байгаа ч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, мэдээлэл солилцох асуудал дутмаг тул гаргасан зөвлөмжийг хэвээр үлдээв.* |
| ***БуААГ-ын тайлбар 10*** | *Хэрэглэгчид эрүүл ахуйн шаардлага хангаагүй газар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа мэдээллийг хэрхэн мэдэгдэх талаар иргэд, хэрэглэгчдэд хийсэн сургалт, сурталчилгаа байхгүй тул уг зөвлөмжийг хэвээр үлдээв.* |
| ***БуААГ-ын тайлбар 11*** | *Тайлангийн 17 дугаар хуудасны 18 дахь мөрний ААНБ гэж заасныг түүвэрт хамрагдсан ААНБ-ын тоог дурдаж оруулլаа.* |
| ***БуААГ-ын тайлбар 12*** | *Тайлангийн 1.14 хэсэгт тусгагдсан хяналт шалгалтын тоо мэдээллийг аудитыг гүйцэтгэх хугацаанд албажуулан өгсөн судалгаанаас авсан тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.* |
| ***БуААГ-ын тайлбар 13*** | *Ирүүлсэн саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан болно.* |

| | |
|---|---|
| ***БуААГ-ын тайлбар 14*** | *Ирүүлсэн тайлбарыг хүлээн авч тайланд тусгасан болно.* |
| ***БуААГ-ын тайлбар 15*** | *Ирүүлсэн тайлбар нь холбогдох нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.* |
| ***БуААГ-ын тайлбар 16*** | *Гүйцэтгэлд хяналт тавин ажилласан нь холбогдох нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.* |
| ***БуААГ-ын тайлбар 17*** | *Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.* |
| ***БуААГ-ын тайлбар 18*** | *МЭГ-ийн лабораторид ажиллахад эрхлэгчийн эрхээр эмч программд нэвтрэх, мэдээлэл харах боломжтой байсан нь тайлбарт ирүүлсэн холбогдох нууцын журмыг бүрэн хэрэгжүүлээгүй эрсдэлтэй тул зөвлөмжийг хэвээр үлдээв.* |
| ***БуААГ-ын тайлбар 19*** | *Тайлангийн 15 дугаар хуудсанд дурдсаны дагуу дээжийн мэдээг улирал бүр гаргадаг бөгөөд улиралд гаргасан дээжийн мэдээллийг нэгтгэж үзэхэд жилийн эцсийн мэдээллээс зөрдөг, дээжид ирж буй бүтээгдэхүүний хэмжих нэгж өөр байсан тул зөвлөмжийг хэвээр үлдээлээ.* |
| ***БуААГ-ын тайлбар 20*** | *Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.* |
| ***БуААГ-ын тайлбар 21*** | *Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.* |

**ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төрөөс батлан хэрэгжүүлсэн хөтөлбөр хоорондын уялдаа хангалтгүй, зорилт бүрэн хэрэгжээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, үр дүнд хүрээгүй байна.
2. Хүнсний салбарт хэрэгжиж буй хууль, бусад актуудын хэрэгжилт хангалтгүйгээс хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлж байна.
3. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах цогц зорилт хөтөлбөр хангалттай хэрэгжээгүй, бодит үр дүн гараагүй байна.
4. Стратегийн улирлын нөөцийн хүнсэнд зөвхөн махыг тодорхойлсон бөгөөд уг нөөцийн хүнсний тооцоо судалгаа байхгүй, лабораториуд итгэмжлэлээр тодорхойлсон үзүүлэлт бүрээр шинжилгээ хийдэггүй, хүнсэнд хэрэглэж ихэнх хувь нь шинжилгээнд хамрагдахгүй байна.
5. МЭГ-ын лаборатори 2020 онд итгэмжлэлийн хүрээний бус үзүүлэлтээр антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг 34 махны, 46 сүүний дээжид хийсэн, МЭГ-ын шинжилгээнд ирж буй дээжийн хариу, бүртгэлийг шинжээч эмч нар бүрэн харах боломжтой байгаа нь хараат бус байдал алдагдах, шинжилгээ үнэ зөв гарахгүй байх эрсдэл үүсээд байна.
6. ЭМГ-аас зөвлөн тусалснаар ямар үр дүнд хүрсэн, алдаа зөрчил хэр хэмжээнд буурсан, хоол тэжээлийн хэмжээ зохистой хэмжээнд байгаа эсэх, тандалт судалгаа хийгээгүй, хоол тэжээлийн илчлэгийг МХГ-ийн лабораторид байгууллагууд хүргүүлж тодорхойлуулдаг ч стандарт хэмжээнд нийцэж буй эсэхэд хяналт тавьж ажиллахгүй байна.
7. Орон нутаг дахь хүн амын хүнсний хэрэгцээ, хангамжийг тооцоолдоггүй, нийт үйлдвэрлэл, хэрэглээ, хэрэгцээг холбогдох мэргэжлийн байгууллага нотлох

баримтгүй, бодит бус мэдээлэлд үндэслэн тооцоолол хийсэн нь иргэд, олон нийт, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахгүй байна.

8. Статистикийн хэлтэс хүн амын хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээлийн болон чанар, эрүүл ахуйн үзүүлэлтийг аймаг, сумын хэмжээнд тооцон гаргадаггүй, ХХААГ-ын мэргэжилтэн нотлох баримт, бодит бус мэдээлэлд үндэслэн тооцоолол хийсэн нь иргэд, олон нийт, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахгүй байна.
9. Хүнсний сүлжээнд тавих хяналт сулаас иргэд, хэрэглэгчид чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсийг хэрэглэж байгаа нь СХЗХ-ийн шинжээч, МХГ-ын байцаагчийн хараат бус байдал алдагдсан байх эрсдэл өндөр байна.
10. Аймгийн хэмжээнд хүнсний сүлжээний бүх үе шатанд нэгдсэн хяналт, бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй, инновац нэвтрүүлсэн, шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрөл байхгүй байна.
11. Хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэж буй сав, баглаа боодол, хаяг, шошгод тавих хяналтын тогтолцоо алдагдсан, эрүүл ахуйн шаардлага хангаагүй газар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байвал зохих журмын дагуу мэдээлдэг, шуурхай арга хэмжээ авдаг жишиг байхгүй байна.
12. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох сайжруулах чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч үр дүнгүй байна.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд баталж, шалгуур үзүүлэлтээр хүрсэн үр дүнг тооцон хяналтыг хэрэгжүүлж байх;

Аймгийн Засаг даргад:

1. Үндэсний хөтөлбөрийг орон нутаг хэрэгжүүлэхдээ хуулиар олгогдсон аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан батлуулж, удирдан зохион байгуулж, шалгуур үзүүлэлтээр хүрсэн үр дүнг тооцон тайлагнаж, хяналтыг хэрэгжүүлж байх;
2. Хүнсний тухай хуульд заасны дагуу стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлэхдээ тооцоо судалгаанд үндэслэн боломжит гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлж үр дүнг тооцон ажиллах;
3. Хяналт шалгалтын үр дүн, шийдвэртэй танилцан аймгийн ИТХ-д холбогдох саналыг хүргүүлж шийдвэрлүүлэх,
4. Аймгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн инновац нэвтрүүлсэн, шим тэжээллэг болон органик хүнсний чиглэлээр сургалт, олон нийтэд хандсан сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг үнэлж хэвших;

Мэргэжлийн хяналтын газарт:

1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг аргачлалын дагуу хөтөлж хэвшүүлэх, зохих арга хэмжээг авч ажиллах;

2. Хүнсний үйлдвэрлэлд гарал үүсэл нь тодорхой, шинжилгээгээр баталгаажсан, хаяг шошгын шаардлага хангасан хадгалах нөхцөлийн дагуу зориулалтын агуулахад төрөлжүүлэн хадгалах, бүртгэлийг бүрэн хөтлүүлж хэвшүүлэх;
3. Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийг оновчтой бөгөөд хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах;
4. Мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог байх, хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах;
5. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй газар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байвал зохих журмын дагуу мэдээлдэг, шуурхай арга хэмжээ авдаг жишиг тогтоох;
6. Иргэдийн хүнсний аюулгүй байдал, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлийг түвшинг тогтоох тандалт судалгаа хийх, түүн дээр үндэслэн сургалт, сурталчилгааг төлөвлөх, үр дүнг тооцож байх;

Стандарт хэмжил зүйн хэлтэст:

1. Тохирлын үнэлгээнд хамрагдаж буй үйлчилгээг үнэлэхдээ хараат бус, үнэн зөв үнэлэх;
2. Мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог байх, хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах;

Мал эмнэлгийн газарт:

1. Лабораторийн дээжийн шинжилгээг хараат бус, үнэн зөв гарах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах;
2. Лабораторийн дээжийн бүртгэлд үзүүлэлт бүрээр бус, нэгж тоо хэмжээ холилдсон тодорхой бус байгаа тул статистик мэдээг үнэн зөв, бодиттой мэдээлэл гаргах нөхцөлийг хангах;
3. Антибиотикийн үлдэгдэл тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчний мэргэших сургалтад хамруулах;

Эрүүл мэндийн газарт:

1. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын талаар тандалт, судалгаа хийх;
2. Орон нутгийн ЕБС, СӨБ, ЭМТ-ийн хоолны шим, тэжээлийг стандартын хэмжээнд нийцүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах;
3. Хоол хүнсний аюулгүй байдлын талаар хийсэн тандалт, судалгаа, авч хэрэгжүүлсэн ажлыг дүгнэж саналыг холбогдох орон нутгийн байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;
4. Иргэдийн хүнсний аюулгүй байдал, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлийг түвшинг тогтоох тандалт судалгаа хийх, түүн дээр үндэслэн сургалт, сурталчилгааг төлөвлөх, үр дүнг тооцож байх;

Хүнс хөдөө аж ахуйн газарт:

1. Мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог байх, хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах;
2. Мэргэжилтнүүдийг боловсруулсан судалгаа, тоон мэдээний үнэ зөв, бодиттой, баримттай мэдээлэлд үндэслэсэн эсэхэд хяналт тавьж ажиллах;

## ХАВСРАЛТУУД:

*Мал эмнэлгийн лабораторид 2019 онд шинжилгээнд хамрагдсан дээж*

*/Хавсралт 1/*

| Агуулга | Булган сум | | | Бусад сум | | | Нийт | Эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ААНБ | Иргэн | МХГ-ын байцаагчаас | ААНБ | Иргэн | МХГ-ын байцаагчаас | | Булган сум | Бусад сум |
| Мах | 4 | 202 | | 2 | | | 208 | 99% | 1% |
| Сүү | 3 | 25 | 3 | 2 | 8 | | 41 | 76% | 24% |
| Өндөг | | | | | 2 | | 2 | 0% | 100% |
| Дүн | 7 | 227 | 3 | 4 | 10 | 0 | 251 | 94% | 6% |

*Эх сурвалж: МЭГ-ийн лабораторийн 2019 оны шинжилгээний түүврээс*

Мал эмнэлгийн газрын лабораторийн 2020 оны дээж

*/Хавсралт 2/*

| **№** | **Байгууллага** | **Махны дээж** | **Эзлэх хувь** | **Сүүний дээж** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сургууль | 22 | 11% | | 0% |
| 2 | Цэцэрлэг | 31 | 15% | 3 | 7% |
| 3 | Ясли | 4 | 2% | | 0% |
| 4 | МСҮТ | 3 | 1% | | 0% |
| 5 | Зоогийн газар | 7 | 3% | | 0% |
| 6 | Цайны газар | 5 | 2% | | 0% |
| 7 | Ресторан | 1 | 0% | | 0% |
| 8 | АЗДТГ | 3 | 1% | | 0% |
| 9 | Дэлгүүр | 2 | 1% | | 0% |
| 10 | Хүнсний зах /номын титэм, баясуулагч/ | 7 | 3% | 2 | 5% |
| 11 | ХХК | 14 | 7% | 3 | 7% |
| 12 | Иргэн | 109 | 52% | 33 | 80% |
| **Нийт** | | **208** | **1** | **41** | **1** |

*Эх сурвалж: МЭГ-ийн лабораторийн 2020 оны шинжилгээний түүврээс*

## Мэргэжлийн хяналтын газрын 2016-2020 онд шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний дээж

*/ Хавсралт 3 /*

| Д/Д | ҮЗҮҮЛЭЛТ | 2016 он | | | | 2017 он | | | | 2018 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дотоод | | Импорт | *Нийт* | Дотоод | | Импорт | *Нийт* | Дотоод | | Импорт | | *Нийт* |
| | | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | Шинжилгээнд хамрагдсан | | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | Шинжилгээнд хамрагдсан | | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | |
| 1 | Мах махан бүтээгдэхүүн | 12 | 1 | 0 | *12* | 52 | | | *52* | 34 | | | | *34* |
| 2 | Сүү | | | | *0* | | | | *0* | 4 | | | | *4* |
| 3 | Сүүн бүтээгдэхүүн | 11 | 0 | 0 | *11* | 6 | | 1 | *7* | 11 | | | | *11* |
| 4 | Гурил | 20 | 1 | 0 | *20* | 42 | | | *42* | 27 | 1 | | | *27* |
| 5 | Гурилан бүтээгдэхүүн | 66 | 0 | 0 | *66* | 138 | 4 | | *138* | 121 | 15 | | | *121* |
| 6 | Төрөл бүрийн будаа | 1 | 0 | 5 | *6* | 9 | | 34 | *43* | | | 20 | | *20* |
| 7 | Сахар, чихрийн зүйл | | | 11 | *11* | | | 25 | *25* | | | 26 | | *26* |
| 8 | Төмс | 16 | | | *16* | 67 | 1 | | *67* | 111 | | | | *111* |
| 9 | Хүнсний ногоо | 26 | | | *26* | 159 | | | *159* | 436 | | | | *436* |
| 10 | Жимс, жимсгэнэ | 5 | 0 | 2 | *7* | 11 | 2 | 7 | *18* | 6 | | 69 | 1 | *75* |
| 11 | Буурцагт ургамал | | | | *0* | | | | *0* | | | | | *0* |
| 12 | Өндөг | | | | *0* | 5 | | 1 | *6* | 1 | | | | *1* |
| 13 | Хүнсний тос | 1 | | | *1* | | | | *0* | 1 | | | | *1* |
| 14 | Ундны ус | 1 | | | *1* | 13 | | | *13* | 14 | | | | *14* |
| 15 | Ундаа жүүс | 2 | | | *2* | 4 | | 1 | *5* | 3 | | | | *3* |
| 16 | Архи пиво | | | | *0* | 3 | 3 | | *3* | 1 | 0 | 1 | 1 | *2* |
| 17 | Үр тариа, бусад үрсэлгээ | 102 | 15 | | *102* | 411 | 57 | | *411* | 965 | 242 | 55 | 2 | *1020* |
| 18 | Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн | | | | *0* | | | | *0* | | | 2 | | *2* |
| 19 | Бусад | 28 | 1 | 2 | *30* | 53 | 2 | 5 | *58* | 218 | 6 | | | *218* |
| | **Нийт дүн** | **291** | **18** | **20** | **311** | **973** | **69** | **74** | **1,047** | **1,953** | **264** | **173** | **4** | **2,126** |

| Д/Д | ҮЗҮҮЛЭЛТ | 2019 он | | | | 2020 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дотоод | | Импорт | *Нийт* | Дотоод | | Импорт | | *Нийт* |
| | | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | Шинжилгээнд хамрагдсан | | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | Шинжилгээнд хамрагдсан | Шаардлага хангаагүй | |
| 1 | Мах махан бүтээгдэхүүн | 50 | 1 | | *50* | 39 | 4 | | | *39* |
| 2 | Сүү | | | | *0* | | | 3 | | *3* |
| 3 | Сүүн бүтээгдэхүүн | 10 | 4 | 2 | *12* | 9 | | 1 | | *10* |
| 4 | Гурил | 28 | | | *28* | 36 | 1 | | | *36* |
| 5 | Гурилан бүтээгдэхүүн | 192 | 7 | | *192* | 144 | 4 | | | *144* |
| 6 | Төрөл бүрийн будаа | 2 | | 30 | *32* | | | 36 | | *36* |
| 7 | Сахар, чихрийн зүйл | | | 19 | *19* | | | 18 | | *18* |
| 8 | Төмс | 95 | 2 | | *95* | 126 | 2 | | | *126* |
| 9 | Хүнсний ногоо | 258 | 1 | | *258* | 370 | 9 | 20 | | *390* |
| 10 | Жимс, жимсгэнэ | 25 | 1 | 36 | *61* | 35 | 1 | 127 | 6 | *162* |
| 11 | Буурцагт ургамал | | | | *0* | | | | | *0* |
| 12 | Өндөг | 3 | | | *3* | 4 | | | | *4* |
| 13 | Хүнсний тос | 2 | | 1 | *3* | 2 | | 1 | | *3* |
| 14 | Ундны ус | 265 | 4 | | *265* | | | 2 | | *2* |
| 15 | Ундаа жүүс | 4 | | 2 | *6* | | | | | *0* |
| 16 | Архи пиво | | | | *0* | | | | | *0* |
| 17 | Үр тариа, бусад үрсэлгээ | 625 | 74 | | *625* | 284 | 86 | | | *284* |
| 18 | Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн | 332 | 47 | 2 | *334* | | | | | *0* |
| 19 | Бусад | 188 | 10 | 27 | *215* | 186 | 55 | 31 | 6 | *217* |
| | **Нийт дүн** | **2,079** | **151** | **119** | **2,198** | **1,23 5** | **162** | **239** | **12** | **1,474** |

*Эх сурвалж: Лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн сангийн маягтаа*

Аймгийн 2018-2020 оны гол нэрийн хүнсний хангамж

*/ Хавсралт 4/*

| № | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн | 2018 он | 2019 он | 2020 он | 2019 оны өөрчлөлт | 2020 оны өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мах | 325.3% | 104.0% | 363.2% | -221.2% | 259.2% |
| 2 | Махан бүтээгдэхүүн | 6.3% | | 29.3% | -6.3% | 29.3% |
| 3 | Сүү | 393.3% | 0.5% | 173.6% | -392.8% | 173.1% |
| 4 | Сүүн бүтээгдэхүүн | 1.8% | 45.2% | 59.3% | 43.4% | 14.1% |
| 5 | Гурил | 107.5% | 53.4% | 0.9% | -54.1% | -52.5% |
| 6 | Гурилан бүтээгдэхүүн | 16.5% | 49.1% | 8.9% | 32.6% | -40.1% |
| 7 | Төрөл бүрийн будаа | 0.4% | 2067.9% | 1.9% | 2067.5% | -2065.9% |
| 8 | Сахар, чихрийн зүйл | 0.4% | 0.0% | 0.0% | -0.4% | 0.0% |
| 9 | Төмс | 1.4% | 244.3% | 243.2% | 242.9% | -1.1% |
| 10 | Хүнсний ногоо | 1.3% | 19.5% | 38.9% | 18.2% | 19.5% |
| 11 | Жимс | 0.2% | 10.4% | 1.6% | 10.3% | -8.8% |
| 12 | Өндөг | 5.8% | 25.1% | 7.8% | 19.3% | -17.3% |
| 13 | Буурцагт ургамал | 0.1% | 4.6% | 0.0% | 4.5% | -4.6% |
| 14 | Шувууны мах | | 0.2% | 0.0% | 0.2% | -0.2% |
| 15 | Загас | | 16.7% | 0.0% | 16.7% | -16.7% |
| 16 | Ургамлын тос | | 0.0% | 3.8% | 0.0% | 3.8% |
| 17 | Цөцгийн тос | | 60.1% | 2.2% | 60.1% | -57.9% |
| Нийт дундаж | | 66.2% | 168.8% | 55.0% | 102.6% | -113.8% |

*Эх сурвалж: ХХААГ-ын хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоол, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтний 2018-2020 оны судалга*

## Мэргэжлийн хяналтын газрын 2016-2020 оны төлөвлөгөөт шалгалт

*/ Хавсралт 5/*

| № | Хяналт шалгалтын нэрс | Нийт объектын тоо, оноор | | | | | Хугацаа, оноор | | | | | Шалгалтанд хамрагдсан хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | Дундаж |
| | **Төлөвлөгөөт хяналт шалгалт** | **1203** | **1243** | **1463** | **1504** | **1655** | **156** | **126** | **136** | **150** | **109** | **151%** | **88%** | **48%** | **49%** | **47%** | **77%** |
| 1 | Хүнсний чанар, стандартын хяналт | 519 | 535 | 592 | 607 | 705 | 69 | 59 | 35 | 55 | 26 | 13% | 11% | 6% | 9% | 4% | 9% |
| 2 | Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт | 519 | 535 | 592 | 607 | 705 | 32 | 30 | 56 | 49 | 37 | 6% | 6% | 9% | 8% | 5% | 7% |
| 3 | Мал эмнэлгийн хяналт | 140 | 148 | 154 | 154 | 117 | 27 | 23 | 23 | 24 | 28 | 19% | 16% | 15% | 16% | 24% | 18% |
| 4 | Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт | 25 | 25 | 125 | 136 | 128 | 28 | 14 | 22 | 22 | 18 | 112% | 56% | 18% | 16% | 14% | 43% |

*Эх сурвалж: МХГ-ын иргүүлсэн судалгаа*

## *Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2018-2020 оны баталгаажуулалт*

*/ Хавсралт 6/*

| Д/д | Он | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | | Гүйцэтгэлийн биелэлт % | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бүтээгдэхүүн | Үйлчилгээ | Бүтээгдэхүүн | Үйлчилгээ | Бүтээгдэхүүн | Үйлчилгээ |
| 1 | 2018 | 30 | 220 | 9 | 232 | 30% | 105% |
| 2 | 2019 | 30 | 271 | 35 | 160 | 117% | 59% |
| 3 | 2020 | 35 | 160 | 4 | 187 | 11% | 117% |
| Нийт | | 95 | 651 | 48 | 579 | 158% | 281% |
